



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХХҮИИ.40.ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид төрийн өмчийн барилгыг ашиглуулах, түрээслүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байрлах Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй (хуучнаар Мэргэжлийн хяналтын газрын) конторын барилгын ашиглалт үйлчилгээ, хадгалалт, хамгаалалтыг “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид бүрэн хариуцуулж, 1, 2 дугаар давхрыг (түрээсийн жишиг төлбөрийг 50 (тавин) хувиар бууруулан) 3500 төгрөгөөр тооцож түрээслүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Барилгын ашиглалтын зардлыг 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани хариуцаж, 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс түрээсийн гэрээ байгуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулахыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамир, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нарт даалгав гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132320117

28-r_huraldaan.docx